



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 01/150

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүтээн байгуулалтын ажил эхэлж байгаатай холбогдуулан хангагч байгууллагуудын уялдаа холбоог ханган, өмнө хийгдсэн зөрчил дутагдал илэрч буй ажлуудад мэргэжлийн дүгнэлт гаргаж цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, шинээр хийгдэх ажлуудад мэргэжлийн байгууллагуудын зүгээс зөвлөмж гаргах, нэгдсэн хяналт тавих зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

-Аймгийн ерөнхий архитектор бөгөөд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Нарийн бичиг:

-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн бөгөөд Чингис хотын архитектор

-Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга

-Аймгийн мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

-Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ий Хэнтий аймаг дахь газрын инженер

-Хэнтий-Ус ХХК-ий ерөнхий инженер

-Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ий Хэнтий аймаг дахь Цахилгаан түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер

01 624

2//.

2. Хийж гүйцэтгэсэн ажлын тайланг "Дэд бүтцийн ажлын зөвлөл"-д танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/Д.Баярхүү/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА